

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

ЧӨЛӨӨТ БҮСИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Чөлөөт бүсийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалт, 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалт:

“3.1.11.эдийн засгийн хамтын ажиллагааны бүс” гэж хил залгаа улсын хилийн боомтын газар нутагт Засгийн газар хоорондын хэлэлцээрт үндэслэн байгуулсан чөлөөт бүсийг.”

2/6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг:

“6.3.Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулж болох бөгөөд уг чөлөөт бүсэд баримтлах бодлого, чиглэлийг холбогдох улстай байгуулсан гэрээгээр зохицуулна.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг “Монгол, Хятадын Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг Монгол Улсын Их Хурлаар соёрхон баталсан хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг